

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ

2020 оны жилийн эцэс

2020.11.30

Цагаандэлгэр сум

Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилт	Хувь
Ерөнхийлөгчийн зарлиг					
1	6	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	ЗДТГ, ЭМТ зэрэг байгууллагууд гадна талын хаягийг монгол бичгээр бичиж байршуулсан. Мөн сургуулийн бэлэг тэмдэг болсон логоны хаягаа монгол бичгээр бичсэн. Бусад байгууллагуудыг үндэсний бичгээр нэр хаягаа бичиж байршуулах үүрэг өгсөн. 	70
ҮАБЗ-ийн зөвлөмж					
2	10	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар,	2.2. Хүн амын ундны ус хангамжийн баталгаат байдлыг хангах үүднээс хот, суурин газрын ус хангамжийн эрүүл	Цагаандэлгэр сумын хүн амын ундны усны худагт ИТХ-ын шийдвэрээр хамгаалалтын бүс тогтоосон. Ундны усны худгийн судалгааны мэдээллийг боловсруулж 	70

	11	аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	бүсийг тогтоон, хамгаалалтад авч газар олголт хийхгүй байх, газар чөлөөлөх ажлыг орон нутгийн удирдлагууд шуурхай зохион байгуулах.	солбилцолын цэгийг авч системд оруулсан. Хамгаалалтын зурвас тогтоосон уст цэгийн ойролцоо шинээр газар олголт хийхгүй байх, суурин газрын ус хангамжийн эрүүл бүсийн зурваст хамаарагдах айлын судалгаа гаргах чиглэлийг баримталж байна.	
			2.3. Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлэх зорилгоор усны сан бүхий хамгаалалтын бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргааны хийсэн уст цэгийн судалгаатай танилцаж Цагаандэлгэр сумын гүний усны хяналтын цооногийг очиж шалган өмнөх жилүүдийнхээс хэрхэн өөрчлөгдөж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж хяналтын цооногийн ажиллах зарчимтай танилцсан. Цагаандэлгэрт нийт 234 уст цэг, 8 булаг улирлын чанартай урсаж байна. Сумын төвийн ундны усны эрүүл ахуйг хангахаар гаднах талбайг хашаажуулсан. Мөн Хүйтэн шандын булгийн эхийг хашиж хамгаалсан байна.	100
ЗГ-ын тогтоол					
3	35	Жагсаалт батлах тухай 2020-01-22 Дугаар 2020_21	3.. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.	Худалдан авах ажиллагааны (tender.gov.mn) цахим системээр хүүхдийн цэцэрлэг, ЕБСургуулийн үдийн цайны тендерийг зарласан боловч оролцох ААНэгж байгаагүй.	70
4	45	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106	2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-ээр тус сум нь 94%-тай сайн үнэлэгдэж 3-р байранд шалгарсан. Улсын үзлэгээр гарсан зарим анхаарах асуудлыг сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажилласан. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулахаар 2019 онд байгууллагын төсөвт 900000 төгрөгийг суулгаж, архивын өрөөнд 1ш төмөр шүүгээг байршуулсан. 2020 онд дахин нэг шүүгээг нэмж байршуулахаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн ба ингэснээр архивын өрөө бүхэлдээ стандартын тавиуртай болох юм.	100
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
5	82	2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22	ХҮИИ.2. . 2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт		

		дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22	даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах.	2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг (tender.gov.mn) цахим системд байршуулсан. Тухайн онд Covid-19 цар тахалтай гарсантай холбогдуулан тендер зарлаагүй.	100
6	85	2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дүгээр тэмдэглэл	IX.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн	Тус сумын төсвийн 5 байгууллагад нийт 75 төрийн албан хаагч ажиллаж байна. 2020 оны санхүүгийн жилд албан хаагчдад	

		2020-04-29 Дугаар 2020_28	албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах.	нийт 228,825.4 мянган төгрөгийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгож ажилласан байна. Үүнд: - Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 42 албан хаагчид 39,643.9 мянган төгрөг - Ур чадварын нэмэгдлийг 12 албан хаагчид 8988.0 мянган төгрөг - Зэрэг дэвийн нэмэгдлийг 2 албан хаагчид 3454.0 мянган төгрөг - Онцгой нөхцлийн нэмэгдлийг 6 албан хаагчид 12457.9 мянган төгрөг - Зэргийн нэмэгдлийг 8 албан хаагчид 10374.1 мянган төгрөг - Улирлын үр дүн, урамшууллыг 54 албан хаагчид 56637.6 мянган төгрөг - Орон нутгийн нэмэгдлийг 37 албан хаагчид 33080.7 мянган төгрөг - Анги даалтын нэмэгдлийг 8 багшид 8229.8 мянган төгрөг - ЗАН-ийн нэмэгдлийг 2 багшид 892.1 мянган төгрөг - Илүү цагийн нэмэгдлийг 11 албан хаагчид 13708.5 мянган төгрөг - Хортой нөхцлийн нэмэгдлийг 2 ажилтанд 79352 төгрөг - Түлээ нүүрсний хөнгөлөлтийг 65 албан хаагчид 19650.0 мянган төгрөг - Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 3 багшид 12181.8 мянган төгрөг - Төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарсан 1 ахмадад 9448.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж тус тус олгогдсон байна. 2021 онд тэтгэвэрт гарах 4 ажилтанд 39157.1 мянган төгрөгийг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжинд 4 ажилтанд нийт 17,147.4 мянган төгрөгийг тус тус 2021 оны төсөвт тусган батлуулсан.	100
7	86	2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл 2020-05-13 Дугаар 2020_31	ХҮ.4. . Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд мал аж ахуйн	Тус сумаас 2020 онд үндэсний үйлдвэрт ноос тушааж урамшуулалд хамруулахаар Уран нинж ХХК-д 11 өрхийн 3549 кг хонины ноос, Чойр хайрхан ХХК-д 25 өрхийн 6868 кг хонины ноос, 1 өрхийн 50 кг тэмээний ноос, Дулаанбэлэг хоршоонд 52 өрхийн 16199 кг хонины ноос, Үлэмж кашмер	

			гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХХК-д 62 өрхийн 17022 кг хонины ноос, Жи Эс Эф ХХК-д 9 өрхийн 5050 кг хонины ноос, Сор кашемир ХХК-д 24 өрхийн 7695 кг хонины ноос, Хатант интернэшил ХХК-д 3 өрхийн 897 кг хонины ноос, 1 өрхийн 110 кг тэмээний ноос, Бампүлс ХХК-д 2 өрхийн 1090 кг хонины ноос, Интернэшил ХХК-д 3 өрхийн 816 кг хонины ноос тус тус тушаан урамшуулалд хамрагдах болсон байна. 141 өрхөд 51551 кг хонины ноосонд, 3 өрхийн 310 кг тэмээний ноосонд, 317 малчин, мал бүхий иргэдийн 64566 ямааны ноолууранд тус тус урамшуулал бодогдон олгогдлоо. Бог малын хээлтүүлэгч, бух ээмэглэхээр “Тэргүүн сүрэг трейд” ХХК-тай Хүнс хөдөө аж ахуйн газраас 1156200 төгрөгийн малын ээмэг гэрээ хийн ээмэгжүүлж төлбөрийг 100% барагдуулан ажилласан.	100
ЗГ-ын албан даалгавар					
8	95	Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай 2020-02-10 Дугаар 2020_01	1.. Хүн, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж, отор нүүдэл, өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх, “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг болон “Журам, чиглэл батлах тухай” Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас дараах албан даалгаврыг өгч байна: Нэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт: 1.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж гарган харьяалах нутаг дэвсгэртээ хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;	Сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/19 тоот захирамжаар үхсэн мал, амьтны хүүр сэг зэм цуглуулж устгах ажлын хэсгийг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 4 дүгээр сарын 01-ний өдөр 57 км явж үхэр 2, хонь 7, ямаа 6, адуу 1, нохой 2, зээр 10 нийт 28 мал, амьтны сэг, зэмийг цуглуулж устгасан байна. Усны үерт үхсэн малын сэг зэмыг цуглуулж устгах ажилд сумын төрийн байгууллагын эрэгтэй албан хаагчдыг дайчлан 380 орчим бог малыг сэгийг цуглуулж устгасан.	100

	96		1.2. Мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, уг ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, мөн олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэн энэ ажлын зорилго ач холбогдлыг өргөн сурталчлах;	Сэг зэм устгалын ажилд сумын хог тээврийн машин болон иргэн О.Цэвэл-очир, Ж.Дэлгэрбаатар, Х.Цэрэндорж нарыг дайлан оролцуулсан. Мөн үерт урсаж хорогдсон бог малын сэг зэмийг цуглуулж устгах ажилд төрийн байгууллагын эрэгтэй албан хаагчдыг мөн тухайн малын эзэн малчин өрхүүдийн ачааны 3 машиныг дайчлан ажиллуулсан. Сэг зэм устгах ажилд 60 л шатахуун, албан хаагчдын хоол хүндсэнд 200.0 төгрөгийг зарцуулсан байна. 	100	
9	102	Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай 2020-02-10 Дугаар 2020_01	3.. Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд: 3.1 Мэргэжлийн байгууллагын заавар, удирдамжийн дагуу мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн ажилд идэвхтэй оролцох; 3.2 Малын хашаа хороог цэвэрлэх, хөрзөнг гадагш гаргаж хураах ажлыг 05 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэж, халдваргүйтгэл хийх; 3.3 Өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа мал, амьтны сэг, зэмийг цуглуулан устгах, булах, уст цэг, булаг шандны эхийг цэвэрлэх, хамгаалах ажлыг гэрээт мал эмнэлгийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран гүйцэтгэх;	Сэг зэм устгалын ажилд сумын хог тээврийн машин болон иргэн О.Цэвэл-очир, Ж.Дэлгэрбаатар, Х.Цэрэндорж нарыг дайлан оролцуулсан. Мөн үерт урсаж хорогдсон бог малын сэг зэмийг цуглуулж устгах ажилд төрийн байгууллагын эрэгтэй албан хаагчдыг мөн тухайн малын эзэн малчин өрхүүдийн ачааны 3 машиныг дайчлан ажиллуулсан. Мал эмнэлгийн тасгаас сэг зэмийг устгаж булсны дараа тухайн газар орчмыг ариутгаж халдваргүйжүүлсэн.	100	
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ						92%